



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгнө Тарнын байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/42/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: Bulgan@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Цэдэнлхам Утас:9982-8263 Цахим хаяг: Tsedenkham@audit.gov.mn</p>
-------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.08.24 № 130

танай _____ ны № _____ Т

ХӨГНӨ ТАРНЫН БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОР ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ГОНЧИГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгнө тарнын байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөгнө тарнын байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Өмнөх оны аудитлагдсан санхүүгийн үр дүнгийн тайланд элэгдлийн зардлыг нэмэгдүүлснээс, санхүү байдлын тайлангийн хуримтлагдсан үр дүн, барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, авто тээврийн хэрэгсэл, бусад хөрөнгийн дансны эхний үлдэгдлийг нийт 31.4 сая төгрөгөөр өөрчилсөн.
- Цалингийн зардалд нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэлтэй төрийн албан хаагчдын ажилласан жилийн мэдээллийг хянаж, засварлаагүйгээс төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1 албан хаагчид 1.1 сая төгрөгийг илүү олгосон.
- Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь дахь заалтаар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 14 гүйлгээний 513.2 сая төгрөгийг

6326050287

мэдээлээгүй, 6.4.8 заалтаар долоо хоногийн дотор мэдээлэх "бонд, зээл, ерийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэр"-ийг хагас, бүтэн жилээр 2 удаа бөөнөөр нь мэдээлсэн.

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, 57 дугаар зүйлийн 57.2 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолтой нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Хөгнө тарнын байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа нь Байгаль орчин, уур амьгалын өөрчлөлтийн яамны сайдтай 6 зорилт, 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг 90.6 хувь "маш сайн" гэж үнэлүүлсэн байна.

Төсвийн зарлага хязгаарлаж, Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар гарсантай холбоотой өглөгийн данс 37.9 сая төгрөг, авлага данс 57.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	43,773.2	119,570.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	584,779.5	562,455.1
	Нийт хөрөнгийн дүн	628,552.7	682,025.9
	Нийт өр төлбөрийн дүн	-	37,939.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	628,552.7	644,086.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	628,552.7	682,025.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	841,073.2	647,303.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	856,930.2	636,918.8
	Үйл ажиллагааны үр дүн	(15,857.0)	10,384.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(15,857.0)	10,384.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	642,796.3	633,702.7
	Тайлант оны үр дүн	(14,243.6)	10,384.2
	Эцсийн үлдэгдэл	628,552.7	644,086.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	841,073.2	594,586.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	725,703.8	594,586.1
	Үйл ажиллагааны ЦМГ	115,369.4	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(39,609.4)	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	75,760.0	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	699,773.0	520,814.8
	Урсгал зардал	699,773.0	520,814.8
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	699,773.0	520,814.8
	Улсын төсвөөс санхүүжих	694,493.0	516,314.8
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	5,280.0	4,500.0

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөгнө Тарнын байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа нь эрхэм зорилгоо “Тусгай хамгаалалттай газар нутгийн экологийн тэнцвэрт байдал, унаган төрхийг хадгалах зорилгоор судлан шинжлэх, хойч үедээ өвлүүлэх байгаль орчныг хамгаалахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж байгалийн баялагийг зохистой ашиглахтай холбогдсон хууль тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад

стандартыг хэрэгжүүлэхэд хамгаалалтын эрхэм зорилго оршино” гэж тодорхойлсон байна.

Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2030 онд “30 ХУВЬ” зорилтыг дэвшүүлж, Тусгай хамгаалалтын газар нутгийн хамгаалалтын захиргааны зөвлөлдөх уулзалт болон, хамгаалалтын захиргааны бодлого, төлөвлөлт, санхүүжилтийн тогтолцоог шинэ түвшинд сайжруулах, 2026 оны ажлын төлөвлөгөөг шинэ шатанд гаргах зорилготой байна.

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар 90.6 хувьтай үнэлүүлэн “бүрэн хангалттай” үнэлгээ авсан байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга;
- Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Сангийн сайдын холбогдох журам зааварт өөрчлөлт орсон байна.

Тайлант онд Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайдтай гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, жилийн эцсээр 90.6 хувьтай үнэлүүлэн “маш сайн” үнэлгээ авсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Тав. Аудитын гол асуудал

Хөгнө тарнын байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа нь Байгаль орчин, уур амьгалын өөрчлөлтийн яамны сайдтай 6 зорилт, 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг 90.6 хувь “маш сайн” гэж үнэлүүлсэн байна.

Төсвийн зарлага хязгаарлаж, Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар гарсантай холбоотой өглөгийн данс 37.9 сая төгрөг, авлага данс 57.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 175 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроож, хугацаа болоогүй 5 мэдээлэл байна. 5.0 сая төгрөгөөс дээш 583.5 сая төгрөгийн 18 орлогыг мэдээлэхээс 73.3 сая төгрөгийн 4 орлогыг мэдээлж, 510.2 сая төгрөгийн 14 орлогын гүйлгээг мэдээлээгүй, 10.0 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж ажилласан байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, дараа оны төсвийн төслийг мэдээлэхдээ файл хавсаргаагүй, өмч, хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг тухай бүр нь мэдээлдэггүй, хагас бүтэн жилээр мэдээлсэн.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төлөвлөгөөнөөс давж биелсэн үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын зарцуулалт, тайлагналт хяналт тавих.

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 155.2 сая төгрөгийн алдаа, зөрчил¹ илэрснээс 122.7 сая төгрөгийн 4 алдааг залруулж, залруулагдаагүй 31.4 сая төгрөгийн зөрчилд 1 алдаанд зөвлөмж, 1.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 1 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 31.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 24.5 сая төгрөгөөр их тул ***Хязгаарлалттай*** дүгнэлт өглөө.

Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Төрийн захиргааны алба хаасан хугацааны нэмэгдлийг 1 албан хаагчид үндэслэлгүйгээр дутуу тооцож 1.1 сая төгрөгийг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам" зөрчсөн нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

Зөвлөмж

Илрүүлэлт 1: 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитлагдсан тайлангийн эхний үлдэгдлийг өөрчилж Байгаль орчин, уур амьсгалын яаманд нэгтгүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа үйлчилгээний зардлын зарим өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, үлдэгдлийн баталгаа байхгүй.	1	1.5					1	1.5				
2025 оны жилийн эцэст татагдсан үйл ажиллагааны нэмэлт орлогыг Санхүүгийн байдлын тайланд авлагаар тусгаагүй.	1	57.4					1	57.4				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн тохируулах бичилт хийгээгүй, зардлаар тайлагнасан.	1	63.8					1	63.8				
Өмнөх оны газрын төлбөрийн өглөгийг дутуу бүртгэсэн.	1	0.009					1	0.009				
Өмнөх оны аудитлагдсан тайлангийн эхний үлдэгдлийг өөрчилсөн.	1	31.4							1	31.4	1	31.4
Дүн	5	154.1					4	122.7			1	31.4

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1 албан хаагчид үндэслэл, шийдвэргүйгээр нэмэгдүүлэн олгосон.	1	1.1	1	1.1								
Дүн	1	1.1	1	1.1	-	-	-	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	1	69.0					1	69.0
Дүн	1	69.0					1	69.0